

Аудит хийгдсэн байгууллага:

“БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨААТУГ-ЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН НОРМ,  
НОРМАТИВЫН САН

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ  
ДОТООД АУДИТЫН ХОРОО

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

**ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000**

**АУДИТ ХИЙСЭН  
БАЙГУУЛЛАГА:**

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯМНЫ “ДОТООД  
АУДИТЫН ХОРОО”**

**АУДИТ ХИЙГДСЭН  
БАЙГУУЛЛАГА:**

**“БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨААТУГ-ЫН БАРИЛГА  
БАЙГУУЛАМЖИЙН НОРМ, НОРМАТИВЫН САН**

**АУДИТЫН ТӨРӨЛ:**

**ДОТООД АУДИТ**

**АУДИТЫН ХУГАЦАА:**

**2024.06.04-2024.07.31**

**Ажлын хэсгийн ахлагч:**

Х.Ган-Очир

**Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод  
аудитын газрын дарга**

**Гишүүн:**

А.Гэрэлт-Од

**Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод  
аудитын газрын, ахлах шинжээч**

Д.Мөнгөнсувд

**Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод  
аудитын газрын, ахлах шинжээч**

Ц.Ууганбаяр

**Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод  
аудитын газрын шинжээч**

**Нарийн бичгийн дарга:**

Б.Цолмон-Эрдэнэ

**Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод  
аудитын газрын шинжээч**

АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА
2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ
  - 2.1 Аудитын зорилго
  - 2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт
  - 2.3 Аудитын арга, аргачлал
3. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА
  - 3.1 Засаглалын талаар
  - 3.2 Эрсдэлийн удирдлагын талаар
  - 3.3 Дотоод хяналтын системийн талаар
4. АУДИТЫН ҮР ДҮН
5. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

## 1. ТАНИЛЦУУЛГА

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 04 дүгээр тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн норм, нормативын сангийн журам”, Барилга, хот байгуулалтын сайдын дэргэдэх “Дотоод аудитын хороо”-ны 2024 оны төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм, 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ын дагуу “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын Барилга байгууламжийн норм, нормативын сангийн 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн тайланг танилцуулж байна.

## 2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

### 2.1 Аудитын зорилго:

“Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын Барилга байгууламжийн норм, нормативын сангийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүгнэлт, санал, зөвлөмж өгөх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, удирдлагыг мэдээллээр хангахад оршино.

### 2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

“Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын Барилга байгууламжийн норм, нормативын сангийн 2023 оны төлөвлөлт, гүйцэтгэл санхүүгийн тайланд санхүүгийн дотоод аудитыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Санхүүгийн баримт бичиг, бүртгэл хөтлөлт, зориулалт, зарцуулалт, гүйцэтгэл
- Аудит, хяналт шалгалтын тайлан, зөвлөмжийн хэрэгжилт
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

### 2.3 Аудитын арга, аргачлал

“Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын удирдлагад дотоод аудитын зорилго, хэрэгжүүлэх зарчмаа танилцуулж, засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцооны талаар асуулга авсан. Мөн аудитын хамрах хүрээнд багтаасан асуудлуудын хүрээнд байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн байдал, бүтэц орон тоо зэргээс олж авсан мэдээлэл, бичиг баримтад дүн шинжилгээ хийж, түүврийн аргаар сорил хийлзээ. Аудитын эдгээр горимын үр дүнд, дотоод аудитын баг хангалттай аудитын нотолгоо цуглуулж, аудитын дүгнэлтээ гаргасан болно. Дотоод аудитыг хэрэгжүүлэхэд дараах хууль эрх зүйн баримтуудыг эх үүсвэр болгон ашиглалаа.

- Дотоод аудитын олон улсын мэргэжлийн практикийн хүрээ /ОУМПХ/
- Улсын салбарын дотоод аудитын гарын авлага
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хуупь

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

### 3.БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА

#### 3.1. Засаглалын талаар

Засгийн газрын 2012 оны 47 дугаар “Аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулах тухай” тогтоолоор “Барилгын хөгжлийн төв” аж ахуйн тооцоотой төрийн өмчит газар байгуулагдсан.

“Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын дүрмийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 85 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар, зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалт, орон тооны хязгаарыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 173 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан байна.

Барилга, хот байгуулалтын сайдар жил бүр гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө батлуулж, хагас болон бүтэн жилээр үнэлүүлдэг. 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 93.7 хувьтай үнэлэгдсэн байна.

“Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ нь “Барилгын салбарын хөгжлийг түргэтгэгч, дэмжин туслагч, түншлэгч байгууллага байна” гэж эрхэм зорилгоо тодорхойлж, барилга байгууламжийн норм, норматив боловсруулах, зураг төсөлд магадлал хийх, техникийн хяналт тавих, сургалт, судалгаа хийх, үндсэн үйл ажиллагааны чиглэлийн дагуу чиг үүрэг бүхий Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

“Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиг үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

1. Барилга, байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн өөрчилж, шинэчилсэн тогтолцоог бий болгох, шинэчлэх, барилга, орон сууц, нийтийн аж ахуйн салбарын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн ашиглалт үйлчилгээг сайжруулах төсөл хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, санал боловсруулах;
2. Барилга байгууламжийн зураг төслийг хөгжүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход чиглэсэн заавар, журам боловсруулж мөрдүүлэх, хэрэгжүүлэх, мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулах,
3. Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн талаар явуулах төрийн бодлого, хөгжлийн ойрын ба хэтийн чиглэлийг хууль эрх зүйн хүрээнд хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, “Баталгаажуулалтын алба”-ны үйл ажиллагааг өргөжүүлэх мэргэжлийн удирдамж, зөвлөгөө, шаардлагатай судалгаа мэдээллээр холбогдох эрх бүхий байгууллагыг хангах;
4. Урт, дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хүрээнд салбарын хүний нөөцийн эрэлт, нийлүүлэлт (захиалга, төлөвлөлт, зохицуулалт)-ийн судалгаа хийх, барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, салбарын бодлого, төсөл, хөтөлбөрийн

хэрэгжүүлэхтэй холбогдсон судалгаа, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа, дэвшилтэт техник технологи танилцуулах, эмхэтгэл гаргаж хэрэглэгчдэд хүргэх ажлыг зохион байгуулах,

5. Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан улсын төсөв, бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих эрх шилжсэн төсөл, арга хэмжээнд техникийн хяналт тавих;

6. Барилгын материал, хийц бүтээц, эдлэхүүний шинж чанарыг Монгол улс болон олон улсад мөрдөгдэж байгаа стандартын дагуу тодорхойлох, орон нутгийн барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхэд арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;

7. Төвийн удирдлагын манлайллыг хангах, дотоод хяналтыг сайжруулах, дотоод ажлыг эрхэлж, олон нийттэй харилцах, төвийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл, боломжийг бүрдүүлж, дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн хэрэгжилтийн үр нөлөөг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;

8. Байгууллагын санхүү, эдийн засгийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэх, санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

### 3.2. Эрсдэлийн удирдлагын талаар

“Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын захирлын А/92 дугаар тушаалаар “Байгууллагын эрсдэл бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлуулсан. Төлөвлөгөөнд 14 эрсдэлийг тодорхойлж эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч ажилласан. Хамгийн өндөр эрсдэлээр тодорхойлогдсон Хуучирсан норм, нормативын баримт бичгүүдийг шинэчилж тухайн үйл ажиллагаатай холбоотой эрсдэл бууруулах арга хэмжээ авч ажиллах ажлын хүрээнд Норм, нормативын баримт бичигт үзлэг хийх санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэх гэх мэтээр үе шаттайгаар эрсдэлийг бууруулах чиглэлээр ажиллаж байна. Стандарт хэмжил зүйн газраас зохион байгуулагдсан MNS ISO 31000:2020 Эрсдэлийн менежмент, Удирдамж сургалтад 2022 оны 11 дүгээр сарын 2, 3-ны өдрүүдэд хамрагдан Эрсдэлийг хэрхэн тодорхойлох, эрсдэлийг бууруулах, дүн шинжилгээ хийх гэх зэрэг мэдлэгийг сургалтаас олж авсан.

Чанарын менежментийн тогтолцооны ISO9001:2015 стандартын хүрээнд Байгууллагын үйл ажиллагааны “Эрсдэлийн удирдлагын журам”-ыг Төвийн захирлын 2023 оны 12-р сарын 05-ны өдрийн А/636 дугаартай тушаалаар батлуулж, эрсдэлийг 2 жил тутамд тодорхойлж, эрсдэлийг бууруулж ажиллахаар заасан байна.

### 3.3. Дотоод хяналтын системийн талаар

“Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын захирлын 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/621 дугаар тушаалаар “Дотоод аудитын журам”, А/622 дугаар тушаалаар “Төвийн үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах журам”, А/630 дугаар тушаалаар “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг тус тус батлан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилладаг. Захиргаа, удирдлагын хэлтсийн харьяанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын албаны бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байсан бөгөөд 2024 оны 6 дугаар

сараас эхлэн “Дотоод аудит, хяналт, шинжилгээний хэлтэс” болж бүтэц шинэчлэгдсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын албаны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 22 арга хэмжээг тусган боловсруулсан. Үүнд: Төвийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх ажлын хүрээнд 16 арга хэмжээ, бусад зорилтын хүрээнд 6 арга хэмжээг тусгаж 2023 оны 2 дугаар сард Төвийн захирлаар батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар гүйцэтгэж дууссан арга хэмжээ 17, Үргэлжлэн хийгдэж байгаа арга хэмжээ 3, хүлээгдэж байгаа арга хэмжээ 4 гүйцэтгэлтэй ажилласан байна.

#### 4. АУДИТЫН ҮР ДҮН

<b>Илэрсэн Асуудал 1</b>	Санхүүжилтийн анхан шатны баримтыг үйлдэх тухай
<b>Асуудлын ангилал</b>	Нэлөө багатай
<b>Бодит байдал:</b>	
Сангийн санхүүжилтийн анхан шатны баримт болох зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ, гэрээт ажлын явцыг дүгнэсэн акт Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль, Сангийн сайдын баталсан журмын дагуу бус үйлдэгдсэн байна.	
<b>Байх ёстой шаардлага /шалгуур/:</b>	
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоол “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, “Сангийн сайдын 2012 оны 194 дүгээр тушаал “Зөвлөх үйлчилгээний тендерийн жишиг баримт бичиг”, 2021 оны 124 дүгээр тушаал “Харьцуулалтын аргаар зөвлөхөөс бусад үйлчилгээ авах тендерийн жишиг баримт бичиг” тус тус мөрдөн ажиллаж санхүүжилтийн анхан шатны баримтыг эдгээр жишиг маягт заавар хуудасны дагуу үйлдэн үйл ажиллагаандaa мөрдөн ажиллах шаардлагатай. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 2023 оны 12 дугаар сарын 01-ны өдрөөс хүчин төгөлдөр болсонтой холбоотойгоор Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоол “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоо тухай”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоол “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянах, тайлагнах журам” болон Сангийн сайдын А/257-А/262 дугаар тушаалаар батлагдсан тендерийн жишиг баримт бичгүүдийн дагуу гэрээ, гэрээ дүгнэсэн акт маягтыг өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллах ёстой.	
<b>Асуудлын үндсэн шалтгаан:</b>	
Барилга байгууламжийн норм, нормативын сангийн санхүүгийн үйл ажиллагаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль болон хуулийн хэрэгжилтийг хангуулах Сангийн сайдын гаргасан журамтай нийцэхгүй байна.	
<b>Байгууллагад үзүүлэх нэлөө /үр дагавар/:</b>	
Холбогдох журам зааврыг зөрчсөн.	
<b>Зөвлөмж:</b>	
- Барилга байгууламжийн норм, нормативын сангийн санхүүжилтийн анхан шатны баримтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан	

авах тухай хууль болон хуулийн хэрэгжилтийг хангуулах Сангийн сайдын гаргасан журмын дагуу үйлдэн үйл ажиллагаандaa мөрдөн ажиллах.

<b>Илэрсэн Асуудал 2</b>	Албан томилолтын мөнгөн урьдчилгааны тайлан, томилолтын тайлангийн бүрдэл дутуу
<b>Асуудлын ангилал</b>	Нөлөө багатай

**Бодит байдал:**

Тайлант онд ТНБД-ын Б/28, Б/202 дугаар тушаалын дагуу гадаад албан томилолтын зардлыг гаргасан байна. Мөнгөн урьдчилгааны тайлан, томилолтын гүйцэтгэлд тавих хяналт хэрэгжүүлээгүй байна.

**Байх ёстой шаардлага /шалгур/:**

Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бodoх бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг ах ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар"-ын 6 дугаар зүйлийн 6.2 "Мөнгөн урьдчилгааны тайлан нь гадаад, дотоод албан томилолт, хангамжийн урьдчилгаа гэх мэт бүх төрлийн мөнгөн урьдчилгааны гүйцэтгэлийг тайлагнах үндсэн баримт юм. Урьдчилгаа авагчийн гаргасан гүйцэтгэл ба олгосон урьдчилгаа, холбогдох анхан шатны баримттай харьцуулан нягтлан бодогч урьдчилгаа тайланг хянах ба илүү/дутуу зарцуулалтыг урьдчилгааны зориулалт тус бүрээр гаргана. Хянасан дүн гэсэн баганад нягтлан бодогч баримтаар нотлогдож, тооцсон дүнг бичих ба илүү эсвэл дутуу зарцуулалтыг урьдчилгааны зориулалт бүрээр холбогдох мөрөнд бичнэ", Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 тоот тушаалын хавсралтын "Мөнгөн урьдчилгааны тайлан"-ын дагуу мөнгөн урьдчилгааны тайлан гаргаж, томилолтын тайлан хавсаргах ёстой.

**Асуудлын үндсэн шалтгаан:**

Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бodoх бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатын баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайландаа тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

**Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:**

Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар" журмыг мөрдөж ажиллаагүйгээс зөрчил давтагдаж, нягтлан бodoх бүртгэлийн санхүүгийн тайлан иж бүрэн, үнэн зөв байх зарчмыг алдагдуулж байна.

**Зөвлөмж:**

- Албан томилолтын мөнгөн урьдчилгааны тайлан, томилолтын гүйцэтгэлд хяналт тавин ажиллах.

<b>Илэрсэн Асуудал 3</b>	Гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй санхүүжилт олгосон тухай
<b>Асуудлын ангилал</b>	Нөлөө багатай

**Бодит байдал:**

2023/121 дугаар ажил гүйцэтгэх гэрээний гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй санхүүжилт олгосон байна.

**Байх ёстой шаардлага /шалгур/:**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль болон хуулийн хэрэгжилтийг хангуулах Сангийн сайдын гаргасан журам, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 04 дүгээр тушаал " Барилга байгууламжийн норм,

нормативын сангийн журам" болон Ажил гүйцэтгэх гэрээний дагуу гэрээ дүгнэсэн акт үйлдэж гэрээг дүгнэн гэрээний дагуу санхүүжилт олгох шаардлагатай.

**Асуудлын үндсэн шалтгаан:**

Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бodoх бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланда тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

**Байгууллагад үзүүлэх нэлөө /ур дагавар/:**

Нягтлан бodoх бүртгэлийн санхүүгийн тайлан иж бүрэн, үнэн зөв байх зарчмыг алдагдуулж байна.

**Зөвлөмж:**

- Барилга байгууламжийн норм, нормативын сангийн санхүүжилтийг гэрээний дагуу ажлыг дүгнэж анхан шатны баримтыг бүрдүүлж ажил гүйлгээг бүртгэх.

Илэрсэн Асуудал 4	Шилэн дансны мэдээлэл хөтлөлтийн талаар
Асуудлын ангилал	Нэлөө багатай

**Бодит байдал:**

"Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн хүрээнд 1-р улирлын тайлангаа хугацаа хоцорч 2023.08.04-ны өдөр илгээсэн байна. 2023 онд Шилэн дансны тухай хуулийн хүрээнд хугацаа хоцорсон 2 мэдээлэл байна.

**Байх ёстой шаардлага /шалгуур/:** Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ыг өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллах ёстой.

**Асуудлын үндсэн шалтгаан:**

Шилэн дансны хуулийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" шилэн дансны зарчмыг алдагдуулсан байна. Мөн Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ын 8.1 "Шилэн дансанд мэдээлэл тавьсан албан тушаалтан, тухайн асуудал хариуцсан нэгж нь байршуулсан мэдээллээ улирал бүр төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албанд дараа сарын 15-ны дотор тайлagnана" гэж заасантай нийцэхгүй байна.

**Байгууллагад үзүүлэх нэлөө /ур дагавар/:**

Хуулийн дагуу хугацаа хоцорсон болон улирлын тайланг хугацаанд нь илгээгээгүйгээс болж эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцогдох, бусад хөндлөнгийн хяналт шалгалтад хамрагдах, олон нийт нийгэмд үзүүлэх сөрөг хандлага зэрэг олон сөрөг нэлөөтэй.

**Зөвлөмж:**

- Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд иж бүрэн байршуулж, улирал бүр шилэн дансны тайланг цаг хугацаанд нь илгээх.

## 5. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Дотоод аудитаар танай байгууллагад “Хангалттай” гэсэн дүгнэлтийг өгч байна.

Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
“Хангалттай”	<p>Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь тус бүртээ “удирдсан буюу З-р түвшин”-ээс дээш байна гэж үзсэн.</p> <p>Аудитаар илэрсэн асуудлуудын 20% хүртэл нь “нөлөө ихтэй” гэж үзсэн</p>

### ТАЙЛАН ХЯНАСАН:

ХШУДАГ-ЫН ДАРГА БӨГӨӨД  
Дотоод аудитын хорооны гишүүн

Х. Ган-Очир

### ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

Дотоод аудитын хорооны  
нарийн бичгийн дарга

Б. Цолモン-Эрдэнэ